

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

ГҮН УТГА, ЗӨӨЛӨН ЭГШГИЙН ХОСЛОЛ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: хөрөг нийтлэл, намтар зохиол, зүй тогтол, хүний дууч, үйл бүтээл, үнэ цэнэ, теле нэвтрүүлэг.

Наяад оны сүүл хэрд До.Чулуунбаатар гэдэг залуухан сэтгүүлч Монгол телевизэд ажиллах болж, тэр үеийн нийгмийн амьдралын аль эгзэгтэй, хөндүүр хэрнээ хүмүүс төдийлөн анзаарахгүй байсан асуудлыг хөндсөн ухаалаг бөгөөд уянгатай нэвтрүүлгүүдээрээ үзэгчдийн сэтгэлийг татаж эхэлсэн билээ. Тэдгээр нэвтрүүлгүүд үзэгчид төдийгүй мэргэжлийн хүрээнийхэнд утга агуулга, ур чадварын үлгэр жишээ болж байсан гэхэд хилсдэхгүй биз.

Далаас наядад оны дунд үеийг улс төр судлаачид “зогсонги” үе гэж томъёолдог. Нийгмийн хөгжил саарч мухардалд ороод байсан шиг сэтгүүл зүй ч нэг хэв загварт баригдаж голын чулуу шиг мөлгөр магтаал урсгаж байлаа. Чухам тэр үед сэвэлзэж эхэлсэн өөрчлөн байгуулалтын салхийг гярхай хэрсүү нийтлэлээрээ хагалагчдын нэг нь До.Чулуунбаатар байсан юм.

Хөдөө нутаг, жирийн хүмүүсийн амьдралаар дамжуулж төр засагт том

санаа хэлж чаддаг нь До.Чулуунбаатарын нэвтрүүлгүүдийн онцлог байв. Яг л бага чулуугаар том чулууг доргионо гэдэг шиг. Хийрхэж туйлширдаггүй, хийх ёстойгоо л хийж явдаг ухаант хүмүүсийн амьдралыг яг байгаагаар нь зурж үзүүлэх тэр барил нь нэг талаар олон нийтэд үнэмшилтэй, нөгөө талаар нөлөөлөх чадвар сайтай байсан биз.

До.Чулуунбаатар аливаа юмыг ойж буусан цочмог хурц үг хэлээр дүрсэлдэггүй, харин олон давхар учир зангилааг үр үндсээс нь хөөн тайлж, уянгалаг зөөлөн үг хэл, дүр дүрслэлээр хүний сэтгэлд суулгаж чаддаг өвөрмөц арга барилтай сэтгүүлч билээ. Тийнхүү өөрийн арга барил, өнгө аясыг зарлан гарч ирсэн анхны нэвтрүүлгүүдийн нэг нь “Дэлгэрийн хэдэн буурай” гэдэг теле найруулал байв. Тэр найруулалд цагийн аяс, хүний нүүр харж хувираагүй, номч мэргэн багшийнхаа байгуулж өгсөн хийдийн буурийг үе залган сахиж сайн цагийг хүлээн суугаа өтгөсийн тухай сэтгэл уярам өгүүлсэн байдаг. Төрөлх нутаг, уламжлалт зан заншил, шашин соёлдоо үнэнч ухаант өвгөдийг сэтгэлийн гүнээс хайрлан өрөвдөж хийсэн тэр нэвтрүүлэг тухайн цагтаа цоо шинэ

зүйл байсан төдийгүй зохиогчийн цагийн аясыг урьтаж таних мэдрэмжийг давхар илтгэж байлаа.

Төдөлгүй До.Чулуунбаатар “Үүлэн чөлөөний нар буюу хүний дууль” гэсэн ерөнхий сэдвийн дор жирийн хүмүүсийн амьдралын жишээгээр нийгэмд хандаж чухал асуудал хөндсөн ухаалаг нэвтрүүлгүүд хийж эхэлсэн. Тэдгээрийн дотор “Адуутай бол дуутай”, “Гүрвэл гүйсэн говь”, “Жингийн бараа”, “Нар буцаагүй говь” зэрэг нэвтрүүлэг үзэгчдийн таашаалыг илүү хүлээж байлаа. Тэдгээр нэвтрүүлэгт нийгмийн амьдралд ус агаар шиг хэрэгтэй байсан эв нэгдлийг эрхэмлэх санаа нэвт шингээс-тэй байсан юм. Үүлэн чөлөөний нар шиг богинохон амьдрахдаа бие биесээ хайр-лаж, эв түнжинтэй аж төрөхийг уриалсан нь олон нийтийн сэтгэлд хүчтэй нөлөөл-сөн байх. Нийгмийн амьдралын эгзэгтэй, бас сонирхолтой үед “цахиур хагалсан” нийтлэлээрээ эрч хүчтэй гарч ирсэн До.Чулуунбаатар нэг л өдөр телевизээ орхисон байсан. Хараад өнгөрдөг, бариад уншиж болдоггүй телевизийн нэвтрүүлэг учир дутагдалтай санагдаж, үе үеийнхэнд уншуулах номон хөшөөгөө босгоё гэж бодсон ч байж магад.

Хэрэв тэгж бодсон бол До. Чулуунбаатар алдаагүй, харин хожсон байна. Тэр цагаас хойш хөрөг нийтлэлийн хэд хэдэн ном бичиж, “Амьдын хар нүгэл”, “Эрдэнэсийн эрих”, “Өвгөдийн минь өв юмсан”, “Сэхээтэн”, “Хөлгөн судар цөглөсөн газар”, “Дэм-бээ”, “Дээрхийн гэгээний даллага” зэрэг арав гаруй баримтат киноны зохиогч болж амжсан байна.

Түүний намтар зохиол, хөрөг нийт-лэлийн томоохон төлөөлөгч болохыг

баталсан нэгэн ёсны тайлан нь 2007 онд хэвлүүлсэн “Домог мэт амьдрал” гэдэг ном мөн. Уг номдоо өмнө нь бие даал-ган хэвлүүлсэн “Он цагийн тоос буюу хүн судрын дууль”, “Домог мэт амьдрал”, “Цог хийморийн тууж”, “Ялж дийлэхийн ухаан” гэсэн дөрвөн бүтээлээ цогц-луулжээ.

До.Чулуунбаатарыг хүний тухай дууч гэж хэлж болно. Бодгал хүний үйл хэргийг мөнхжүүлэх гэсэн түүний зорилго өнөө үед хамгийн зөв, ирээдүйтэй зам ч байж болох юм. Учир нь хорвоо гагцхүү хүний амьдралаар амьсгалж, оршин тогтнож байдаг. Бие нь элж дууссан ч хүний үйл бүтээл мөн-хөрч, сургамж нь хойч үед өвлөж байдаг. Магадгүй нэг эрхэм хүн ертөнцөөс халихад нэг их мэдлэг туршлага, нандин чанар түүнтэй хамт төгсдөг. Тэгэхээр амьдад нь хүний ухамсарт амьдралыг бичиглэж үлдээх нь унах гэж байгаа шижир алтыг шүүрний нүхээр тунгааж авахтай агаар нэгэн буй заа. Хүн төрөлхтний хөгжил дэвшил, ололт амжилт, мэдлэг туршлага бүхэн үе үеийн түм буман хүний үйл бүтээлийн үргэлжлэл болж байдаг. Орчин үед баримтат зохиолын үнэ цэнэ өсөх болсон нь ч санамсаргүй зүйл биш. Мэдээллээр хахаж цацсан өнөө үеийн хүмүүс хэдэн зуун хуудас урт сунжруу роман туужийг биш, бодитой баримттай юмыг илүү сонирхох болсон нь жам ёсны хэрэг байх.

Тиймээс зарим судлаач шинэ зуун баримтат уран зохиолын зуун болно гэж барим тавим бичиж, ярих болсон хэрэг. До.Чулуунбаатар тэрхүү зүй тогтлыг эрт мэдэрч, шинэ замаар эргэлтгүй замна-сан байна. Хүн яаж зорилготой, учир

утгатай амьдарч чаддагийг бодит хүний жишээгээр харуулдагт баримтат зохиолын үнэ цэнэ оршдгийг До.Чулуунбаатарын хөрөг нийтлэлүүдээс тодорхой харж болно. Хөрөг нийтлэл бол өргөн утгаараа хүн судлалын бүтээл байдаг. Хүнийг нэвт шувт судлаад ирэхээр зөвхөн зохиолын баатраар зогсохгүй өргөн уудам газар орон, үе үеийн, зүг зүгийн хүнтэй танилцахад хүргэдэг байна. Үүнийг ардын эмнэлгийн нэрт зүтгэлтэн, академич Ц.Хайдавын тухай бичсэн "Он цагийн тоос бууу хүн судрын дууль" хөрөг нийтлэл их тодорхой харуулж байна. Ц.Хайдавын шинжлэх ухаан хийгээд нийгэмд эзлэх байр суурь, зорьсондоо хүрэхийн тулд бусадтай тогтоосон өргөн харилцаа холбоо нь түүний намтрыг нэгэн их модны үй түмэн салаа мөчир шиг харилцааны өргөн сүлжээ болгосон байна. Ганц хүний намтрыг бичихийн тулд Монгол орны өргөн уудам нутгаар хэрэн бэдэрч, янз бүрийн хүнтэй уулзаж ярилцах, тэр ч байтугай тив дэлхийг алгасч, тэнгис далайг гаталсан хүнийг ч эрж хайх шаардлага гарсан нь зохиогчийн цуглуулсан баримт материал, баялаг жишээнээс илт мэдэгдэнэ. Монголын нэг эрдэмтний тухай бичихийн тулд Оросын нэрт жанжин Жуковын түүхийг сөхөж, Якут, Тундрт аж төрдөг сонин хувь тавилантай монгол хүнтэй уулзах ч хэрэг гарсан байна. Үйлс арвинтай хүний тухай үнэнийг бичихийн тулд их хөдөлмөр, гүнзгий судалгаа хэрэгтэй болдогийн жишээ энэ юм.

Уг хөрөг нийтлэлд Ц.Хайдав гэдэг хүн нийгмийн эд эс болж, амьдралд хөлөө олохын төлөө сайн муу элдвийг үзэж, чармайлтынхаа уйгагүй бүтээл хувь

тавилангаа жолоодож байгааг элдэв нэмэр чимэггүйгээр харуулсан нь том ололт болжээ. Тодруулбал зохиолын баатар өөрөө үйлдэж, хөдөлж, хөгжиж байгаа нь нийтлэл бүтээх хэвшмэл загварыг эвдсэн амьд бичлэг болсон байна. Зохиогч өөрөө хураангуйлан тэмдэглэсэнчлэн Ц.Хайдавын "Шувуудын нүүдэл ширтсэн нусгай хүү, хийдийн бяцхан хувраг, өвс хадах машинт станцийн босуул ажилчин, дайны жилийн цэрэг-санитар, өлсгөлөн үхэл нүүрлэсэн орос орны сэргэлэн сурагч, танкийн бригадын эмийн санч, их сургуулийн тарчиг оюутан, хөдөөгийн эмнэлгийн дарга, бага эмч нарын захирал, ардын эмнэлгийг цогцоор сэргээгч, Монгол улсын шинжлэх ухааны хоёр дахь доктор, шинжлэх ухааны гавьяат ажилтан" болтлоо амьдарч тэмцсэн амьд түүхийг уран сайхны өндөр төвшинд бичиглэн үлдээжээ.

Монголын уламжлалт мэдлэг ухааны нэг болсон ардын эмнэлгийг сэргээн хөгжүүлэхийн төлөө 40 гаруй жил тэмцэж, тэрхүү уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны нэг салбар болтол хөгжүүлж, өдий төдий эрдэмтдийг төрүүлж, ном бүтээл туурвиж, хорь гучаад нэрийн эм бэлдмэл гарган авч, эмчилгээнд нэвтрүүлсэн амжилтыг тоочих, тодорхойлох аргаар биш, энгийн үнэн үгээр сэтгэлд унацтай дүрслэн өгүүлж чаджээ. Хэмжээгээрээ багашаархан романы дайтай энэ хөрөг нийтлэлд албадаж хүчилсэн үг өгүүлбэр нэг ч байхгүй, бүгд амьд өгүүлэмж, дүр дүрслэлээр дүүрэн юм. Нийтлэлд болсон явдал, бодит ажил үйлсийг тусгадаг болоод ч тэр үү, хуурай магтаал, тоочлого, модон үг орчих гээд

байдаг зовлон бий гэлцдэг. До. Чулуунбаатар тэр сул талыг аль эрт гэтэлсэн уран бүтээлч юм. Зохиогч хөрөг нийтлэлийнхээ төгсгөлд "Номынхоо эхийг редактортаа уншуулчихаад Туул голын хөвөөнд очив. Намрын шар нар, хотын зэгэл тоосыг алагчлалгүй нуруун дээрээ үүрсэн их гол яаран түргэлэн довтолсоор ... Тэр дунд нэгэн дархи мод урсч явна. Амьдрал гэгч голд автсан тэрхүү унанги дархи шиг хаа зогсч, чухам хаахна очиж хаягдахаа огтхон ч мэдэхгүй. Тэгсэн хэрнээ өөнтөгч зожиг амьдрал гэдэг их мөрөнд адилхан урсч яваа нэгнээ хажиглах нь нэн их" хэмээн бодлогоширч байна. Энэ нь зохиолын үйл явдлын тайлал, нэвтрэн гарах санаа төдийгүй Ц.Хайдав шиг улс эх орон, хүн арддаа тустай юм хийж байгаа хүмүүсийг дэмжиж туслаад, алдаршуулаад байдаггүй юмаа гэхэд адлаж гоочлоод байхгүй юмсан хэмээн нийгэмд хандсан том санаа болжээ.

Монголын нэгэн үеийн сэхээтнүүдийн дунд нэгдүгээр сургуулийн захирал Гомбосүрэн гэж үнэхээр домог болсон сэхээтэн байсныг ахмад үеийнхэн өнөө ч мартаагүй. Сохор зоосыг ч төсөв, төлөвлөгөөнөөс гадуур зарах хориотой байсан үед Гомбосүрэн захирал дэндүү чөлөөтэй задгай ажилладаг хүн байсан гэдэг. Нэгдүгээр сургуулийн багш нар нэгдсэн орон сууцанд амьдардаг гэнэ, сургууль нь амралт зуслан, эдлэн газартай гэнэ, сурагчдаараа ажил

хийлгэж цалин олгодог гэнэ гэх мэт төвлөрсөн төлөвлөгөөт нийгэмд байж боломгүй юм яригддаг байж. Тэгсэн атлаа хэл аманд өртөөд, хийсэн ажил нь буруутаад байдаггүй ёстой л домог болсон сонин аргатай хүн байжээ. Одоогийнхоор бол аж ахуйн овсгоотой менежер байж.

Тэр алдартай, сонин амьдралтай хүн До.Чулуунбаатарын гярхай хараанд ертжээ. Нэрт зохиолч, яруу найрагч Дөнгөтийн Цоодолын онож ажигласнаар До.Чулуунбаатар зүгээр нэг бичихийн тулд бичдэггүй, хэн тааралдсаныг магтаж сайшаагаад байдаггүй хүн юм. Нэг үгээр хэлэхэд хүнээс өөр зан араншинтай содон үйлстнийг хайж, тэдгээрээс хүмүүст өвлүүлэх эрхэм чанарыг шавхаж явдаг өвөрмөц

аргатай сэтгүүлч ажээ.

Хожим Монгол улсын гавьяат багш, боловсролын салбарын домогт удирдагч болсон Гомбосүрэн гэгч хүн хар бага наснаасаа ямар их зовлон бэрхшээлийг туулж, хатуу хүтүүг амсаж явж амьдралд хөлөө олсныг сэтгэл уярч, бишрэл төрмөөр дүрслэн үзүүлж чадсанд энэ хөрөг нийтлэлийн үнэ цэнэ оршиж байна. Ардын сургуулийн алтан босго алхангуутаа бэлэвсэн эхдээ нэмэр болох гэж хар бор ажилд нухлагдсан бяцхан сурагч, Улаанбаатарын багшийн сургуулийн хуваарь авчихаад хүний хуучин гутал хөлдөө углан замд гарсан оюутан, арван зургаахан насандаа багш

«

До.Чулуунбаатар аливаа юмыг ойжс буусан цочмог хурц үг хэлээр дүрслэдэггүй, харин олон давхар учир зангилааг үр үндсээс нь хөөн тайлж, уянгалаг зөөлөн үг хэл, дүр дүрслэлээр хүний сэтгэлд суулгаж чаддаг өвөрмөц арга барилтай сэтгүүлч билээ.

»

болж А үсэг зааж эхэлсэн ардын багш, өмөг түшиг болж байсан Зөвлөлт оронд дайны гал дүрэлзэж асан дөчөөд онд эх орноо хамгаалахаар цэргийн жагсаалд нэгдсэн байлдагч, хожим нь намын ажилтан, дээд сургуулийн оюутан, улмаар нийслэлийн нэгдүгээр дунд сургуулийн багш, захирал гээд Гомбосүрэнгийн туулсан амьдралыг яг л кино тууз мэт дурайтал дүрслэн өгүүлсэн байна. Уг нийтлэл хүн амьдралд ямар их хүч хөдөлмөр, зориг тэвчээр гаргаж байж зорьсондоо хүрч чаддагийг харуулснаараа сургамжтай, өгөөжтэй болжээ.

Түүхийг, тэр тусмаа хүний намтрыг хөндлөнгийн хэн ч тавилгүй дурлаж уншихаар бичнэ гэдэг хэрийн хүнд заяадаг авьяас биш. Тийм чадвар До.Чулуунбаатарт цогцолсон аж. Ардын амьд ярианы хэлийг уран зохиолын хүүрнэлийн аргатай нягт хослуулан, юмны учрыг туйлын энгийн атлаа гүн гүнзгий илэрхийлж чаддаг нь түүний уран бүтээлийн нэг онцлог юм. Энэ нь ардын уламжлалт зан заншлыг зохиол, нийтлэлийнхээ өгүүлэмж бүхэнд шигтгэж өгдөг, баатрын үг хэлийг нас бие, боловсрол мэдлэгт нь тааруулан оновчтой сонгож чаддаг, өөрөөр хэлбэл хүний сэтгэлд туйлын ойр байлгахыг эрмэлздэгтэй нь холбоотой байна. Нэг жишээ татъя. Хот айлынх нь бүсгүй халуун ханиадаар өөд болоход ойр хавьд эр хүнгүй учир Их, бага хоёр Ханд нутаглуулах болж байна. "За би орьё гэж их Ханд эрсхэн хэлэв. Тэгээд урд хормойгоо эргүүлж шуугаад, үсээ сөргүүлж гурав илснээ орж явчихав" гэсэн ганцхан өгүүлбэрт л гэхэд ардын үлэмж нарийн зан үйлийг тусгаад авч

байна. Өтгөс дээдэс минь урд хормойгоо шуухыг, тэр тусмаа эмэгтэй хүнийг бүр ч их хориглодог билээ. Муу үйл хийхэд урд хормой шуудаг учир тийнхүү цээрлэдэг ёсыг үгийн далимд шигтгээд авсан байх жишээтэй. Энэ мэт ардын гүн ухаан, зан заншил, үг хэл зохиолын нийт өгүүлэмжид нэвчмэл байгаа нь уншуурыг сайжруулах бас нэг нөхцөл болсон байна.

До.Чулуунбаатарын хөрөг нийтлэл сэтгэл татам дүр дүрслэлтэй, цаанаа л нэг нүнжигтэй байдгийн өөр нэг учир нь судалгааг сайн хийдэгтэй холбоотой ажээ. Ер нь нийтлэл гэдэг бол судалгааны үр дүн болж биеждэг зүйл юм. Уран зохиол амьдралд түгээмэл байж байдаг хэв шинжит дүрийг бүтээдэг бол нийтлэл бодгал дүрийг бүтээдэг. Буух мөртэй, буцах эзэнтэй бие хүний дүрийг бусдаас зээлдэн бүтээж болдоггүй. Зөвхөн тэр хүнд байдаг, тэхдээ баатрыг чухам "тэр хүн" болгож байгаа, өөр хэнд ч байдаггүй тийм зан араншин бүтээх хэрэгтэй болдог. До.Чулуунбаатарын хөрөг нийтлэлийн баатрууд тийм өөр өөр зан чанартай хүмүүс байх бөгөөд тэднийг ижил төстэй болгож байгааг ганцхан зүйл байгаа нь ирээдүйдээ илтгэлтэй, улс эх орон, хүн арддаа хэрэгтэй юм хийх гэсэн тэдний нийтлэг зорилго юм.

Зохиогч, ардын жүжигчин П.Цэрэндагвын тухай бичихийн тулд бараг элэнц хуланцаас нь наашлуулан хөөж нэвт шувт судалсан байна. Тэр түүхийг хамгийн сайн мэдэх амьд гэрч болсон наян зургаан-настай Хорлоо эмгэний нойр хулжаасан бодлоор хөрөг нийтлэл эхэлж, бас дуусч байгаа нь ч санамсаргүй тохиолдол биш юм. Тэр

түүх өнөөдрийн ардын жүжигчин П.Цэрэндагва ямар удам судартай өтгөсийн дунд хэрхэн хүмүүжиж төлөвшсөнийг бэлхэнээ харуулаад өгч байна. Тэгээд П.Цэрэндагвын өөрийнх нь сэтгэл рүү өнгийгөөд ирэхлээр "Тийм хүмүүсийн үр сад ийм хүн болж төлөвшихөөс өөр яах вэ" гэх сэтгэлийг аяндаа төрүүлнэ. Хэн ч гэсэн өссөн төрсөн орчноосоо хүн болох суурь хүмүүжлээ олж авдгийг хэлэх гэсэндээ зохиогч тийнхүү түүхийн гүнээс нийтлэлээ эхэлсэн биз. Тэгснээрээ ч П.Цэрэндагвын амьдралыг сургууль, соёлын мөр хөөж, улмаар мэргэжлийн жүжигчин, бүр ардын цолтон болсон түүхийн баялаг баримтанд тулгуурлан онц сонирхолтой өгүүлж чадсан юм. "Гарын таван хуруу", "Нянчулууны ой", "Ээдрээ"-гээс эхлээд түүх хувьсгалын сэдэвт жүжиг, кино, тэр ч бүү хэл гадаадын сонгодог жүжгүүдийн гол дүрийг амилуулах бүрдээ дахин төрж, жүжиг кинонд тоглох болгондоо хэн нэг баатрын зовлон жаргалыг бие сэтгэлээрээ туулж өнгөрүүлдгийг нь гайхалтай энгийн мөртөө үнэмшилтэй гаргажээ. Нэгэн насандаа зуу хол давсан дүрийг бүтээсэн нэрт жүжигчний амьдралыг үзэх үзэл, хүн чанар, хүсэл эрмэлзэл, авьяас билгийг бодит хүний давтагдашгүй цогц дүр болгон амилуулж чадсанд "Цог хийморийн тууж" хөрөг нийтлэлийн үнэ цэнэ оршиж байна.

До. Чулуунбаатар хүнийг нэг хоёр уулзалтаар өнгөц судалж, яаруу сандруу бичдэггүй, тухайн хүний өвөг дээдэс, өсөж төрсөн орчин, нутаг ус, зовлон жаргалыг бүрэн судалж мэдээд, тэр бүхнээсээ баатрын дүрийг тодруулахад хэрэгтэй чухал баримтуудыг сугалан авч логик дараалалд оруулан, нийлсэн

тонгорог мэт нийцтэй, мэдрэмжтэй үгээр шаглан урладаг сэтгүүлч юм. Жишээ нь Монголын чөлөөт хэвлэлийн "Загалмайлсан эцэг" гэгддэг, сэтгүүлч Ц.Дашдондовын хөргийг бүтээхдээ "дээрээ ах, эгчгүй, доороо дүүгүй, дэргэдээ хараагүй эхтэйгээ өнчрөн хоцорсон" тэр хүнд хэцүү үеэс нь эхлэн үйл явдлыг цааш өрнүүлэн бичсэн байх жишээтэй. Зовлон жаргал хоёрыг өнгөөр төсөөлбөл хар, цагаан хоёр юм. Хүний амьдрал нэг өнгөөрөө дуусах гэж үгүй. Тэгэхээр хүнийг өндөг шиг өөгүй амьтан болгож магтах, эсвэл жаргалын одонд төрсөн мэтээр дүрсэлж тэмцэгч чанарыг бүрхэгдүүлэх хоёрын аль аль нь хөрөг бичлэгт харш юм.

Хар, цагаан хоёрыг хослуулан байж, гэрэлд гаргаж, сүүдэрт оруулж байж хүний жинхэнэ дүр төрх гарч ирдгийг До.Чулуунбаатар өөрийн хөрөг нийтлэлүүдээр баталж байна.

Хэрвээ өнөөгийн нэрт сэтгүүлч, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, хаа явсан газраа шорвог үнэн үгээрээ сулбагархан сэтгүүлчдийг чичрүүлж, чөлөөт хэвлэл ярьж явдаг Ц.Дашдондовыг зөвхөн одоо байгаагаар нь төсөөлөөд үзвэл байдаг л нэг ахмад сэтгүүлч харагдана. Харин ямар хүнд хэцүү амьдрал дундаас, ямар их холын бодол тээж, эр зориг, тэвчээр хатуужил гаргаж ийм хэмжээнд хүрсэн түүх нь тэр хүний амьдралаас бусдад нөлөөлөх сургамж төдийгүй ерөөсөө Ц.Дашдондовыг жаргаж зовдог, амьдарч тэмцдэг бүхэл бүтэн хүн буюу бодгал болгож байна. Жишээ нь Ц.Дашдондовыг хар багадаа эцгээс өнчин хоцорч, хараа муутай эхийгээ хөтлөн хот хүрээг зорин бэдэрч явсан, амьдрахын эрхэнд

сувилагчийн сургуульд сурч, эмнэлэг, ариун цэвэр, улаан загалмайн ажил хүртэл хийж явсан гэдгийг өнөөдөр хэн ч мэдэхгүй. Хожим эвлэлийн ажилтан болж, улмаар намын дээд сургуульд элсэн гялалзтал сурахын хажуугаар номын амтанд орж, найз нөхдөөсөө “бяцхан марксист” нэр зүүж явсныг ч төдий л санахгүй. Тэр бүхнийг гаргаж өгөх тутам баатрын дүр улам тодорч, уншигчдад өгөх сургамж нь өсдөг байнам.

Ц. Дашдондов бол зохиогчийн өмнөх үгэндээ тодорхойсончлон “Маш олон талтай, тэр бүхэн нь монгол дархны цоож мэт давхар давхар өргөстэй, өөр юутай ч зүйрлэшгүй цор ганц “хувь хүн”, мэргэжлийн хүрээнийхний хэлдгээр бол “хатуу самар” мөн. “Нэг бодоход жигтэйхэн тод томруун, нөгөө бодлын харь холын гариг мэт” хүнийг үнэн мөнөөр нь дүрслэнэ гэдэг амаргүй. Ц.Дашдондов нэгэн цагт бусдын адилаар коммунизмын эрхэм дээд эрмэлзлийг номлогч, МАХН-ын томоохон үзэл сурталч явсан. Гэтэл тэднийхээ дундаас ирэх цагийн өнгийг хамгийн эрт мэдэрч өөрчлөн байгуулалт, шударга ёс, чөлөөт эхлэлийн төлөө тууштай зүтгэж эхэлсэн хүний нэг. Зөвхөн үүнээс л түүний танигдашгүй чанарыг мэдэрч болно. Болзошгүй, гэнэтийн өөрчлөлт, шийдвэрээр дүүрэн байдаг “баатрын” дүр төрхийг бүтээх хариуцлагатай үүргийг До.Чулуунбаатар нэр төртэй биелүүлж чадсан байна.

Эцэст дүгнэж хэлэхэд До.Чулуунбаатар бол хоёр зууны заагт төрж гарсан Монголын хөрөг нийтлэл, баримтат уран зохиолын нэрт төлөөлөгч юм.

Түүний нийтлэлээс монгол ухаан, монгол ахуй нэвт харагдаж, өсөхөөс сурсан үндэсний хэл их мөрний урсгал шиг даруухан бөгөөд утга төгөлдөр уянгалж байдаг онцлогтой байна. Зохиол, нийтлэлийнх нь үг өгүүлбэр бүрээс амьдралын гүн ухаан, ардын цэцэн цэлмэг санаа нэвт гэрэлтэж, санаа сургамж нь хэний ч сэтгэлд нэгийг бодогдуулахаар байдаг нь олзуурхмаар. Энэ бүхнээс үндэслэн түүний нийтлэлийг гүн утга, зөөлөн эгшгийн хослол хэмээн нэрлэж болох мэт.

Ашигласан материал

1. *Чулуунбаатар До.* 2009. Домог мэт амьдрал. УБ.
2. *Баасансүрэн Т.* 1999. Сэтгүүлчийн ур чадварын тухай яриа. УБ.
3. *Баасансүрэн Т.* 2010. Наран, саран, дэлхий. УБ.
4. *Зулькафиль М.* 2009. Сэтгүүлчийн ур чадвар. УБ.
5. *Норовсүрэн Л., Ариунзаяа Н.* 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
6. *Мазнева О. А.* 1990. Структура газетного жанра. М.

Резюме

В настоящей рецензии автор предпринял попытку проанализировать творчество известного монгольского журналиста До. Чулуунбаатара, в частности, мастерство изложения портретного очерка. Портреты Ц. Хайдава, Г. Гомбосүрэна, Ц. Дашдондова и П. Цэрэндагва, опубликованные в его книге “Домог мэт амьдрал” (“Жизнь как легенда”), не только наглядно показывают их жизнь и деятельность, но и поражают тем, как автор смог проникнуть к их самым сокровенным тайнам и дерзновениям. Стилль До. Чулуунбаатара лёгок и изящен, портреты, написанные им, читаются на одном дыхании.